



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 8/22

Ховд


Б.Батцэцэгт цалинтай чөлөө олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.3-ын “а” дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч Батнасангийн Батцэцэг нь Улаанбаатар хот руу хүүхдээ эмчилгээнд авч явах асуудлаар чөлөө хүссэн тул 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Б.Батцэцэгт чөлөөтэй байх хугацааны цалинг бодож олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.САНДАГСҮРЭН